

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛЫН АЖЛЫН БАЙРНЫ СУЛ ОРОН ТООГ НӨХӨХ ТУХАЙ

Нэг. СУЛ ОРОН ТООГ НӨХӨХ ЗАР

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5-д “Хуульд өөрөөр заагаагүй бол ажил олгогч төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны талаар нийтэд мэдээлэх үүрэгтэй” гэсний дагуу Төрийн албаны зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь Салбар зөвлөлөөс ирүүлсэн тус аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх захиалгыг Төрийн албаны зөвлөлөөс нийтэд зарлаж байна.

Зарлагдаж буй сул орон тоонд Төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчид болон төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэлтэй, тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар болон тусгай шаардлагыг хангасан энэ албан тушаалд ажиллахыг хүссэн Монгол Улсын иргэн санал хүсэлтээ гаргаж болно.

Тус аймгийн Нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын дагуу нөхөх үйл ажиллагааг зохион байгуулна.

Төрийн албаны зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөл зарын дагуу бүртгүүлсэн нөөцөд байгаа иргэнийг тухайн ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж байна гэж үзсэн тохиолдолд мэргэшлийн шалгалт өгсөн төрийн жинхэнэ албан тушаалын ангилал, зэрэглэл дотор төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж болно. Өөрөөр хэлбэл туслах түшмэлийн ангилалд хамаарах ажлын байранд шалгалт өгсөн бол дэс түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдон ажиллах боломжгүй юм.

Хоёр. БҮРТГЭЛИЙН ХУГАЦАА

Зарлагдсан төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байрны сул орон тоонд ажиллахыг хүссэн иргэд тус аймгийн Засаг даргын Тамгын газрын 316 тоот өрөөнд 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр 09.00-18.00 цагийн хооронд өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.

Гурав. БҮРТГҮҮЛЭХ ИРГЭДЭД ТАВИХ ШААРДЛАГА

1. Бүртгүүлэх иргэн Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn гэсэн цахим хаягт байгаа “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-тай танилцсан байна
2. Бүртгүүлэх иргэн дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ.
 - Тухайн албан тушаалд ажиллахыг хүссэн өргөдөл /Иргэн ажилд орохыг хүссэн өргөдөлдөө төрийн албаны мэргэшлийн шалгалтыг хэдэн оны хэдэн сард хаана, ямар байгууллага, ажлын байранд өгч тэнцсэн тухай дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ/
 - Төрийн албан хаагчийн анкет (Төрийн албан хаагчийн анкетыг маягт №1-ийн дагуу бүрэн бөглөсөн байх);

- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн эхийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт;
- Мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан бол гэрчлэх баримт бичгийн эх хувийг хуулбарын хамт;
- Иргэний үнэмлэхний эх, хуулбарын хамт
- “4 х 6”-гийн хэмжээний цээж зураг 2 хувь;
- Ажилласан хугацаа болон ажил эрхлэлтийг гэрчлэх баримт /Нийгмийн даатгал, хөдөлмөрийн дэвтэр/-ийн эх хувийг хуулбарын хамт;

Жич: “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 4.1-д зааснаар мэргэшлийн шалгалт өгч тэнцсэн иргэний нөөцийн бүртгэл 2 жилийн хугацаанд хүчинтэй байна.

Дөрөв. МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА

Тус аймаг дахь Нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байрны сул орон тоонд ажиллах хүсэлтэй иргэд аймгийн Засаг даргын Тамгын газрын 316 тоот өрөө болон 7032-3538 дугаарын утсаар холбогдож лавлагаа авч болно.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ӨВӨРХАНГАЙ
АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ**

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ДЭС ТҮШМЭЛИЙН АНГИЛЛЫН ТӨРИЙН
ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛЫН СУЛ ОРОН ТООГ НӨӨЦӨӨС НӨХӨХ ЗАР, АЖЛЫН БАЙРНЫ ТАВИГДАХ ШААРДЛАГА**

2018.10.24

№	Захиалга өгсөн сум, байгууллагын нэр	Нэгжийн нэр	Ажлын байрны				Ажлын байранд тавигдах шаардлага						Сул орон тоо гарсан үндэслэл
			Нэр	Хариуцах асуудал	Ангилал, зэрэглэл	Орон тоо	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага	Ур чадвар	Тусгай шаардлага	
1	Эрүүл мэндийн газар	Эмнэлгийн тусламжийн хэлтэс	Эмийн чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	Эм зүйн тусламж үйлчилгээтэй холбоотой хууль, эрх зүйн акт, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, стандартыг хангуулах, удирдлага арга зүйгээр хангах	дэс түшмэл ТЗ-5	1	Бакалавр	Эм зүйч		Мэргэжлээрээ 1 ба түүнээс дээш жил ажилласан байх	Багаар ажиллах, зохион байгуулах, баримт бичиг боловсруулах, төлөвлөх, асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх, мэргэжлийн дагуу зөвлөгөө, тусламж үзүүлэх чадвартай байх	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчилгүй /хувийн эмийн сангүй байх/	Шалгалтад хүн тэнцээгүй
2		Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс	Ахмад настан, Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн	Ахмад настан болон халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, хянах бодлогын хэрэгжилтийг хангуулах, мэргэжил арга зүйгээр хангах замаар хүн амын эрүүл мэндийг дэмжих, амьдралын чанарыг дээшлүүлж, эрүүл урт наслахад нь дэмжлэг үзүүлэх	дэс түшмэл ТЗ-5	1	Бакалавр	Хүний их эмч		Мэргэжлээрээ 1ба түүнээс дээш жил ажилласан	Багаар ажиллах, зохион байгуулах, баримт бичиг боловсруулах, төлөвлөх, асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх, мэргэжлийн дагуу зөвлөгөө, тусламж үзүүлэх чадвартай байх	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчилгүй	Өөр ажилд шилжсэн
3		Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амд жигд, хүртээмжтэй, чанартай хүргэх	Дэс түшмэл ТЗ-5	1	Бакалавр	Хүний их эмч		Нөхөн үржихүйн эрүүл мэнд болон эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр 1 ба түүнээс дээш жил ажилласан	Багаар ажиллах, зохион байгуулах, баримт бичиг боловсруулах, төлөвлөх, асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх, мэргэжлийн дагуу зөвлөгөө, тусламж үзүүлэх чадвартай байх	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчилгүй	Өөр ажилд шилжсэн

4	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Нарийнтээл суман дахь Мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын цэг	Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч	Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх, шүлхий өвчөөр тайван, вакцин таригдаагүй бүсийг хамгаалах мал эмнэлэг, хорио цээрийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, удирдлагаар хангах, үр дүнг тайлагнах, удирдах дээд байгууллагыг мэдээллээр хангах	дэс түшмэл ТЗ-6	3	Бакалавр	Малын их эмч			Багаар ажиллах, зохион байгуулах, баримт бичиг боловсруулах, төлөвлөх, асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх, мэргэжлийн дагуу зөвлөгөө өгөх чадвартай байх, тусламж үзүүлэх чадвартай байх	мал амьтны эрүүл мэндийн стандарт, хууль эрх зүйн зохих мэдлэгтэй, нэгдсэн дүн шинжилгээ хийх чадвартай	1 байцаагч тэтгэвэрт гарсан, 2 байцаагч өөрийн хүсэлтээр гарсан
5	Боловсрол, соёл, урлагийн газар	Соёл урлагийн хэлтэс	Хөгжим бүжгийн боловсрол хариуцсан мэргэжилтэн	Боловсрол, соёлын байгууллагуудын хөгжим, бүжгийн багш нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах	Дэс түшмэл ТЗ-5	1	Бакалавр	Соёлын менежмент, дуулаач, Хөгжмийн багш	Менежмент, удирдлагын чиглэлээр мэргэшсэн байх	Боловсрол, соёлын байгууллагад мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан байх	Багаар ажиллах, зохион байгуулах, баримт бичиг боловсруулах, төлөвлөх, асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх, мэргэжлийн дагуу зөвлөгөө, тусламж үзүүлэх чадвартай байх	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх:	Өөр ажилд шилжсэн
6	Боловсрол, соёл, урлагийн газар	Сургалт, судалгаа арга зүйн хэлтэс	Математикийн боловсрол хариуцсан мэргэжилтэн	Математикийн боловсролын стандартын хэрэгжилт, багшийн мэргэжил дээшлүүлэх, тэдэнд мэргэжил арга зүйн дэмжлэг тусалцаа үзүүлэх	Дэс түшмэл ТЗ-5	1	Бакалавр	Математикийн багш	Заах аргач зэрэгтэй байх	мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх	Удирдан зохион байгуулах, багаар ажиллах чадвартай, төлөвлөлт хийх; компьютерийн хэрэглээний программуудыг эзэмшсэн, мэргэжлийн дагуу зөвлөгөө, тусламж үзүүлэх.	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх:	Өөр ажилд шилжсэн
7	Онги-Таац голын сав газрын захиргаа	Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах нэгж	Усны барилга, байгууламж, ашиглалт хариуцсан мэргэжилтэн	Төрөөс усны талаар баримтлах бодлого, Усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үйлдвэр, ХАА, ус ашиглалт, усны барилга, байгууламжийн тооцоо, судалгааг гаргах	Дэс түшмэл ТЗ-5	1	Бакалавр	Усны нөөц-экологи, Усны инженер, Усны барилга байгууламжийн инженер	Усны барилга байгууламжийн чиглэлээр мэргэшсэн	мэргэжлээрээ 3 ба түүнээс дээш жил ажилласан байх	Удирдан зохион байгуулах, багаар ажиллах чадвартай, төлөвлөлт хийх; компьютерийн хэрэглээний программуудыг эзэмшсэн, мэргэжлийн дагуу зөвлөгөө, тусламж үзүүлэх чадвартай байх.	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх:	Өөр ажилд шилжсэн

8	Мэргэжлийн хяналтын газар	Дэд бүтэц, хөдөлмөр нийгмийн хамгаалал, байгаль орчин, уул уурхайн хяналтын хэлтэс	Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч	Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай, Ариун цэврийн тухай, Эрүүл мэндийн тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай, Хөдөлмөрийн тухай хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм журмын биелэлт, стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, арга зүйн зөвлөгөө дэмжлэгээр хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах	дэс түшмэл ТЗ-6	1	Бакалавр	Эрүүл ахуйч, нийгмийн эрүүл мэндийн судлаач		Мэргэжлээрээ 3 ба түүнээс дээш жил ажилласан байх	Багаар ажиллах, компьютерийн хэрэглээний программ эзэмшсэн, баримт бичиг боловсруулах чадвартай, гадаад хэлний зохих мэдлэгтэй.	Шударга зарчимч, харилцааны ур чадвартай. Ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, хөндлөнгийн нөлөөлд үл автах, системийн дүн шинжилгээ хийх, илүү цагаар ажиллах	өөр ажилд шилжсэн
9	Аймгийн ЗДТГазар	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Гадаад харилцаа, төсөл, хөтөлбөр, үйлдвэрлэлийн бодлого хариуцсан мэргэжилтэн	Гадаад харилцааг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх чиглэлээр гадны орны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, хамтарч ажиллах	Дэс түшмэл ТЗ-5	1	бакалавр	Англи, Хятад хэлний орчуулагч, Олон улсын харилцаа, бусад	Англи, хятад хэлний ахисан шатны мэдлэгтэй		Англи болон хятад хэлээр ямар ч сэдвийн хүрээнд хурал, зөвлөгөөн, уулзалтад оролцож орчуулга хийх чадвартай	Харилцааны ур чадвартай.	өөр ажилд шилжсэн
СУЛ АЖЛЫН БАЙРНЫ ТОО						11							